

# БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/136/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> Өлгий хот 2024 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: Х.Еркебулан Утас: 99427667 Цахим хаяг: erkebulankh@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
  2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
  3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
    - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
    - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
    - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
    - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
  4. Аудитын тайлан .....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
  6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

**ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 10 ДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ К.ЕРКЕГҮЛ  
ТАНАА**

додт . Од. Дб № ддд  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд онцлох асуудал гараагүй байна.

**Аудитын гол асуудал**

Сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал

00402359

байхгүй.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>108,430,962.60</u></b>	<b><u>163,267,102.73</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	81,014,486.00	135,522,643.13
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	81,014,486.00	135,522,643.13
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	81,014,486.00	135,522,643.13
31211	Төрийн сангийн харилцах	81,014,486.00	135,522,643.13
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	11,701,916.00	10,700,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	8,401,916.00	7,400,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	3,300,000.00	3,300,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,300,000.00	3,300,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	15,714,560.60	17,044,459.60
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	15,714,560.60	17,044,459.60
35460	Хүнсний материал		940,000.00
35470	Бусад хангамжийн материал	15,714,560.60	16,104,459.60
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,461,064,106.27</u></b>	<b><u>3,395,141,616.35</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,461,064,106.27	3,395,141,616.35
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,434,617,668.77	3,369,396,564.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,495,048,697.00	3,495,048,697.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(181,706,292.00)	(268,925,312.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	56,996,432.80	87,401,132.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,965,836.03)	(21,984,872.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,983,736.00	70,903,736.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,034,781.20)	(22,366,206.76)
39217	Ном	22,295,712.20	29,319,390.52
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	26,446,437.50	25,745,051.54
39301	Програм хангамж	8,674,500.00	10,097,739.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,684,062.50)	(4,808,687.46)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,456,000.00	20,456,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,569,495,068.87</u></b>	<b><u>3,558,408,719.08</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,569,495,068.87</u></b>	<b><u>3,558,408,719.08</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,569,495,068.87	3,558,408,719.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,456,000.00	20,456,000.00
51101	Өмч: - төрийн	20,456,000.00	20,456,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	3,549,039,068.87	3,537,952,719.08
51210	Өмнөх үеийн үр дүн	3,549,039,068.87	3,549,039,068.87

51220	Тайлант үеийн үр дүн	-	(11,086,349.79)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,569,495,068.87</b>	<b>3,558,408,719.08</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>974,776,225.60</b>	<b>1,100,404,917.32</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>787,520.60</b>	<b>12,802,917.32</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	787,520.60	12,802,917.32
120009	Бусад орлого	387,520.60	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	400,000.00	12,802,917.32
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>973,988,705.00</b>	<b>1,087,602,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	892,445,605.00	1,027,520,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	831,390,900.00	1,027,520,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	61,054,705.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	81,543,100.00	60,081,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,543,100.00	60,081,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>888,696,948.68</b>	<b>1,111,491,267.11</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>888,696,948.68</b>	<b>1,111,491,267.11</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	796,399,640.68	1,015,019,167.11
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	567,270,473.00	726,915,658.87
210101	Үндсэн цалин	417,884,211.00	494,241,464.80
210102	Нэмэгдэл	119,806,962.00	176,631,499.46
210104	Урамшуулал	29,579,300.00	56,042,694.61
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	66,634,156.00	89,251,600.00
210201	Тэтгэврийн даатгал	44,779,562.00	60,691,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,338,199.00	7,140,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,671,699.00	5,712,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,168,099.00	1,427,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,676,597.00	14,280,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	35,570,398.00	57,036,300.00
210301	Гэрэл, цахилгаан	11,165,029.00	16,636,300.00
210302	Түлш, халаалт	23,405,736.00	32,100,000.00
210303	Цэвэр, бохир ус	999,633.00	8,300,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	458,700.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	458,700.00	2,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	400,000.00	-
210702	Дотоод албан томилолт	400,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,342,000.00	5,147,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,342,000.00	4,997,800.00

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	150,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	121,723,913.68	134,667,808.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,748,136.00	13,874,301.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,526,464.00	8,099,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	103,449,313.68	112,694,107.24
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	92,297,308.00	96,472,100.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	91,985,350.00	95,427,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	75,032,850.00	95,427,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,952,500.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	311,958.00	1,045,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	311,958.00	1,045,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>86,079,276.92</b>	<b>(11,086,349.79)</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>86,079,276.92</b>	<b>(11,086,349.79)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

#### АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>913,334,000.00</b>	<b>1,087,602,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>400,000.00</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	400,000.00	-
120009	Бусад орлого	400,000.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>912,934,000.00</b>	<b>1,087,602,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	831,390,900.00	1,027,520,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	831,390,900.00	1,027,520,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	81,543,100.00	60,081,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,543,100.00	60,081,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>812,417,178.00</b>	<b>999,125,142.87</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>812,417,178.00</b>	<b>999,125,142.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>720,119,870.00</b>	<b>901,713,042.87</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	587,448,434.00	725,913,742.87
210101	Үндсэн цалин	438,062,172.00	493,239,548.80
210102	Нэмэгдэл	119,806,962.00	176,631,499.46
210104	Урамшуулал	29,579,300.00	56,042,694.61
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	66,634,158.00	89,251,600.00
210201	Тэтгэврийн даатгал	44,779,562.92	60,691,500.00

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	5,338,199.02	7,140,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,671,699.41	5,712,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,168,099.61	1,427,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,676,597.04	14,280,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,818,178.00</b>	<b>57,036,300.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,813,029.00	16,636,300.00
210302	Түлш, халаалт	23,405,736.00	32,100,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,599,413.00	8,300,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>458,700.00</b>	<b>2,000,000.00</b>
210604	Урсгал засвар	458,700.00	2,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>400,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	400,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,092,000.00</b>	<b>4,537,800.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,092,000.00	4,537,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>21,268,400.00</b>	<b>22,973,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,616,436.00	13,832,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,651,964.00	9,140,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>92,297,308.00</b>	<b>97,412,100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>91,985,350.00</b>	<b>96,367,100.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	75,032,850.00	96,367,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,952,500.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>311,958.00</b>	<b>1,045,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	311,958.00	1,045,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>100,916,822.00</b>	<b>88,476,857.13</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>19,902,336.00</b>	<b>33,968,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>19,902,336.00</b>	<b>33,968,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>19,902,336.00</b>	<b>33,968,700.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,902,336.00	33,968,700.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(19,902,336.00)</b>	<b>(33,968,700.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>=</b>	<b>=</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>81,014,486.00</b>	<b>54,508,157.13</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>81,014,486.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>81,014,486.00</b>	<b>135,522,643.13</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	20,456,000.00	0.00	<b>3,549,039,068.87</b>	3,569,495,068.87
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>20,456,000.00</b>	<b>0.00</b>	<b>3,549,039,068.87</b>	3,569,495,068.87
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			<b>0.00</b>	0.00
D01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>20,456,000.00</b>	<b>0.00</b>	<b>3,549,039,068.87</b>	3,569,495,068.87
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>20,456,000.00</b>	<b>0.00</b>	<b>3,549,039,068.87</b>	3,569,495,068.87
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-11,086,349.79	-11,086,349.79
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>20,456,000.00</b>	<b>0.00</b>	<b>3,537,952,719.08</b>	3,558,408,719.08

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		81,014,486.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,168,616,500.00</b>	1,032,048,842.87

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,168,616,500.00</b>	1,032,048,842.87
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,057,637,400.00	935,681,742.87
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	828,744,000.00	725,913,742.87
210101	Үндсэн цалин	553,001,600.00	493,239,548.80
210102	Нэмэгдэл	225,788,800.00	176,631,499.46
210104	Урамшуулал	49,953,600.00	56,042,694.61
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	103,593,000.00	89,251,600.00
210201	Тэтгэврийн даатгал	70,443,300.00	60,691,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,287,400.00	7,140,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,629,900.00	5,712,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,657,500.00	1,427,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,574,900.00	14,280,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	58,081,300.00	57,036,300.00
210301	Гэрэл, цахилгаан	17,151,300.00	16,636,300.00
210302	Түлш, халаалт	32,380,000.00	32,100,000.00
210303	Цэвэр, бохир ус	8,550,000.00	8,300,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,094,000.00	6,077,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,094,000.00	6,077,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	59,125,100.00	55,402,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,984,200.00	46,261,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,140,900.00	9,140,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	110,979,100.00	96,367,100.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	110,979,100.00	96,367,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	110,979,100.00	96,367,100.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,087,602,000.00</b>	<b>1,086,557,000.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,027,520,700.00	1,027,520,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,027,520,700.00	1,027,520,700.00

<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	60,081,300.00	59,036,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	60,081,300.00	59,036,300.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		81,014,486.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		135,522,643.13
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	47.00	45.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	23.00	23.00
620003	Үйлчлэх ажилтан	18.00	16.00
620004	Гэрээт ажилтан	5.00	5.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	1.00	1.00
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	1.00	1.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	1.00	1.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>47.00</b>	<b>45.00</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	25.00	23.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17.00	17.00
650010	Гэрээт ажилтан	5.00	5.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль нь бага боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Сургууль нь 2022 онд “Хүүхэд бүрийн сурах үйлийг дэмжиж, сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил, төлөвшил, сурлагын амжилт, чанарын ахиц гаргах багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, хяналт тавих
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах
- Мэдлэг чадвараа дээшлүүлэх
- Эрүүл аюулгүй орчинд суралцах нөхцөл бүрдүүлэх

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккрузал суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас сургуулийн 2022 оны санхүүгийн баримтад баримтын шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11.1 сая төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	81,014.4	135,522.6	54,508.2
Авлага	11,701.9	10,700.0	(1,001.9)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	15,714.6	17,044.5	1,329.9
Үндсэн хөрөнгө	3,461,064.1	3,395,141.6	(65,922.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,569,495.0</b>	<b>3,558,408.7</b>	<b>(11,086.3)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,569,495.0	3,558,408.7	(11,086.3)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,569,495.0</b>	<b>3,558,408.7</b>	<b>(11,086.3)</b>

Мөнгөн хөрөнгө оны эцэст 135.5 сая төгрөг үлдэгдэлтэй гарч оны эхнээс 54.5 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс 74.7 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс, 60.8 сая төгрөг нь бусад зардлаас үлдсэн мөнгө байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 1.0 сая төгрөгөөр буурсан ба тайлант онд ажиллагсадтай холбоотой авлага буурсан байна. 2023 онд Татварын хэлтэст 5.4 сая төгрөгийн цалингийн ашгийг илүү шилжүүлж, тайлант онд 2 ажилтанд шинээр 2.0 сая төгрөгийн авлага үүссэн байна. Урьд оноос 2 ажилтны 3.3 сая төгрөгийн авлага байна.

Бараа материал дансны үлдэгдэл оны эцэст 17.0 сая төгрөг болж оны эхнээс 1.3 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд: хүнсний материал 0.9 сая төгрөгийн, бусад хангамжийн материал 16.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 65.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд тайлант онд төсвийн хөрөнгөөр 33.9 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэгүй 12.8 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, үндсэн хөрөнгөд 112.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 11.1 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 980.8 сая, орон нутгийн төсвөөс 50.0 сая, нийт

зарлагыг 1,030.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас сургуулийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 1,087.6 сая төгрөгөөр хянаж, 106.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан ба эхний үлдэгдлээс 81.0 сая төгрөг нэмж зарцуулахаар нийтдээ 1,087.6 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 60.1 сая төгрөгөөр баталсан ба өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,027.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 60.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 81.0 сая төгрөгийг харилцах дансны эхний үлдэгдлээс санхүүжүүлэхээр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,027.5 сая, орон нутгийн төсвөөс 60.1 сая нийтдээ 1,087.6 сая төгрөгийн санхүүжилт авч, 81.0 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1032.0 сая төгрөг буюу 88.3 хувьтай буюу дансанд 136.6 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ	2,698.5	2,537.2	161.3	94.0.%
2	Сургалт семинар	1,872.1	717.0	1,155.1	38.3.%
3	Эрүүл мэндийг дэмжих	4,326.4	1,920.0	2,406.4	44.4.%
4	Үдийн цай хөтөлбөр	110,979.1	96,367.1	14,612.0	86.8%
5	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	32,428.7	32,428.7	0.0	100.0%
6	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	5,611.5	5,611.5	0.0	100.0%
7	Боловсролын стандарт, сургалт	713,648.1	603,390.8	110,257.3	84.6%
8	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	236,970.8	233,674.2	3,296.6	98.6%
9	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	60,081.3	55,402.3	4,679.0	92.2%
	<b>Нийт дүн</b>	<b>1,168,616.5</b>	<b>1,032,048.8</b>	<b>136,567.7</b>	<b>88.3%</b>

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль нь тайлант онд 1.0 сая төгрөгийг төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуульд 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 129.3 сая төгрөгийн бараа материал, 33.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардал сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 888.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 13.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгав.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1169.2 сая төгрөгийн, 22 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 81.9 сая төгрөгийн, 19 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 43.2 сая төгрөгийн шийдвэрийг шилэн дансанд мэдээлэхээс бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2.9 сая төгрөгийн 2 акт, 69.0 сая төгрөгийн 5 заалттай албан шаардлага, 4 заалттай 80.1 сая төгрөгийн зөвлөмж өгсөн байна. Нэг актын төлбөрийг барагдуулаагүй байна. Зөрчлийг арилгаж албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	2,965.9	1	1,268.2	42.8%

Албан шаардлага	5	69,038.8	5	69,038.8	100.0%
Зөвлөмж	4	80,145.2	4	80,145.2	100.0%
<b>Нийт дүн</b>	<b>11</b>	<b>152,149.9</b>	<b>10</b>	<b>150,452.2</b>	<b>83.3%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл гараагүй. Санхүүгийн тайлангийн аудитаар цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн ба төсвийн зарцуулалтыг гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар 174.7 сая төгрөгийн зөрчил илэрч 0.2 сая төгрөгийн акт тогтоож, 3.3 сая төгрөгийн албан шаардлага, 171.2 сая төгрөгийн зөвлөмж өгөгдлөө.

#### 5.1 Төлбөрийн акт

Цалингаас суутгаж аваагүй 200.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

1.Ажилчдад олгосон цалингийн урьдчилгаа, түүний суутгал, төлөлтийн тооцоог шалгаж үзэхэд авлага, өглөгийн журналыг бүрэн хөтлөөгүй, 200.0 мянган төгрөгийн урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузль суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.2 “бүх авлага”, 20 дугаар зүйлийн 20.2-д “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Суутгаагүй урьдчилгааг нөхөн төлүүлэх акт тогтоов.

#### 5.2 Албан шаардлага

Аудитаар дараах зөрчилд албан шаардлага өгөгдлөө. Үүнд:

1. Сургууль нь санхүүгийн тайлангаар үдийн хоолны төсвөөс 96,367.1 мянган төгрөгийн материал худалдан авч 95,427.1 мянган төгрөгийг үдийн хоолонд зарцуулан, батлагдсан нормыг жилийн дүнгээр 3318.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2021 оны 237 дугаар тогтоолоор баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1500 (нэг мянга таван зуун) төгрөгөөр тогтоосугай.” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

##### 1.1.Илрүүлэлт:

Цалингийн зардлын төсвөөс ажилтнуудад 18,225.0 мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцээгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

#### **2. 1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал**

##### 2.1.Илрүүлэлт:

Түлш халаалт, бичиг хэрэг, хүнсний материал, аж ахуйн материал зэрэг зардлуудын нийт 142,310.8 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

##### 2.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх заавар аргачлалын хэрэгжилтийг хангаж ажиллах.

#### **3. Тооцооноос илүү шилжүүлж үүсгэсэн авлагатай холбоотой асуудал**

##### 3.1 Илрүүлэлт:

Оны эцэст цалингийн зардлын төсвөөс 5,400.0 мянган төгрөгийг цалингаас суутгасан татварын тооцоонд илүү шилжүүлж авлага үүсгэсэн, өмнөх оноос шилжиж ирсэн 2 ажилтантай холбоотой 3,300.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй 2 ажилтантай холбоотой 2,000.0 мянган төгрөгийн авлагыг шинээр үүсгэсэн байна.

##### 3.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, авлага үүсгэсэн зөрчлийг арилгаж, авлагыг барагдуулах.

*Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Үдийн хоолны норматив хэтрүүлсэн	1	3318.1			1	3318.1							
Авлага үүсгэсэн	1	10700.0					1	10700.0					
Цалингийн урьдчилгааг дутуу суутгасан	1	200.0	1	200.0									
Цалингийн зардлаас түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	18,225.0					1	18,225.0					
Шууд зардлаар бүртгэсэн	1	142,310.4					1	142,310.4					
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>174,753.5</b>	<b>1</b>	<b>200.0</b>	<b>2</b>	<b>3318.1</b>	<b>2</b>	<b>171,235.4</b>					

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								